



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
ХҮСЭЛТЭЙ ХУВЬ ХҮН/БАГ/, ХУУЛИЙН
ЭТГЭЭДЭД

2022.03.17 № 03/657
танай _____-ны № _____-т

Шинжээчээр хамтран ажиллах урилга хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газар нь “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитад “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн дуусаагүй орхигдсон зарим барилга байгууламжийн зураг төсөл, төсөвт өртөг, ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргах” зорилгоор гэрээ байгуулан хамтран ажиллахаар төлөвлөж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг мэдээллээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү шинжээч нь YAГ-АД/22-010 дугаартай ажлын даалгаврын дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлын даалгаварт тусгагдсан холбогдох дуусаагүй орхигдсон 13 барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөл, төсөв болон ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргах дараах ажлыг хэрэгжүүлэх бөгөөд ажлын 35 хүртэл хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Барилга, байгууламжийн зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангаж, төлөвлөлт, судалгаанд үндэслэсэн эсэхэд шинжээчийн дүгнэлт гаргах;
2. Барилга, байгууламжийн төсвийг баталсан зураг төслийн дагуу холбогдох хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиож, магадлалаар баталгаажуулсан эсэхэд дүгнэлт гаргах;
3. Барилга байгууламжийн суурь, бүтээц, угсралтын ажлыг зураг төсөл, техникийн шаардлагын дагуу хийсэн эсэхэд дүгнэлт гаргах;
4. Барилга, байгууламжийн гүйцэтгэлийн үе шатны ажлуудад хяналт тавьсан байдал, өгсөн зааварчилгаа, түүнийг хэрэгжүүлж ажилласан байдлыг нягтлан шалгаж, дүгнэлт гаргах;
5. Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад орц, материалын тоо хэмжээ, нэр төрөл, чанар, агууламж зэргийг баталж, хянаж баталсан төсөв болон бодит гүйцэтгэл хооронд зөрүү илэрсэн тохиолдолд гүйцэтгэлийн өртөгт үзүүлэх нөлөөллийг тогтоож, төсөвт гарсан хэмнэлт, хэтрэлтийг тоо хэмжээ болон үнийн дүнгээр гаргах;

Шинжээч нь ажлын даалгаварт дурдсан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, ажлын үр дүнг илтгэсэн шинжээчийн тайлан бичнэ.

Мэдээллээ ирүүлж буй шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн албан хүсэлт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, санхүүгийн дэлгэрэнгүй санал ирүүлэхээс гадна дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

Хуулийн этгээд бол:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын өргүй тухай тодорхойлолт/;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт/;
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл сүүлийн 3 жилээр /2019, 2020, 2021 он/;
- Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;
- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт /2020, 2021 оны жилийн эцсийн/.

Хувь хүн/баг бол:

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Анкет /CV/;
- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;
- Багийн хувьд гишүүдийн хамтран ажиллах гэрээ /нотариатаар баталгаажуулсан/.

Шинжээчид тавигдах шаардлага, ажлын туршлага:

Шинжээч нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хүрээнд хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл, төсөв боловсруулах, магадлал хийх, дүгнэлт гаргах эрх бүхий, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, эдийн засгийн үр өгөөжийг тооцох, үнэлэх талаар мэргэшсэн, энэ чиглэлээр дүгнэлт гаргаж байсан, техникийн үйлчилгээ үзүүлж чадахуйц, тухайн салбарт ажиллаж байгаа болон ажлын дадлага, туршлагатай иргэн, хуулийн этгээд байна.

Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээчийн ажлын хүрээнд мэргэшсэн, тухайн салбарт ажиллаж ирсэн ажлын дадлага, туршлагатай, зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээд /түншлэлээр оролцох/-тэй хамтран ажиллах бөгөөд зөвлөх үйлчилгээг багаар үзүүлнэ. Үүнд:

- Багийн ахлагч нь барилгын инженер, Монгол Улсын зөвлөх инженер, тэргүүлэх төсөвчин, магистр буюу түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 15 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай байх;
- Багийн гишүүд нь мэргэшсэн инженер, бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай байх;
- Судалгаа шинжилгээний болон шинжээчийн ажлын туршлагатай байх.

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болох ба түншлэлийн гэрээ байгуулан баталгаажуулж ирүүлэх шаардлагатай.

Сонирхсон этгээд нь холбогдох мэдээллийг 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө авч болох бөгөөд мэдээллээ 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10 цаг 10 минутын дотор дараах цахим хаягаар /tsend-ayushn@audit.gov.mn, info@audit.gov.mn/ pdf файл хэлбэрээр ирүүлнэ үү. Хариуцсан ажилтан: Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. Гар утас: 88051068

Захиалагчийн хаяг: 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр, 409 тоот өрөө.
Үндэсний Аудитын газар, Утас: 26 35 33. www.audit.mn.

БАТЛАВ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ

Я.САРАНСҮХ

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖСЭН ДУУСААГҮЙ ОРХИГДСОН
ЗАРИМ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ, ТӨСӨВТ ӨРТӨГ, АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛД ДҮГНЭЛТ ГАРГАХ ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР2022 оны 02 дугаар
сарын 22-ны өдөрДугаар 445-101
22-010

Улаанбаатар хот

АЖЛЫН ЗОРИЛГО: Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийх гүйцэтгэлийн аудитын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан дуусаагүй орхигдсон зарим барилга, байгууламжийн зураг төсөл, төсөвт өртөг болон ажлын гүйцэтгэл нь Монгол Улсын хууль тогтоомж, барилга, байгууламжийн норм, дүрэм, стандарт шаардлагад нийцэж байгаа эсэх, дуусаагүй орхигдсон шалтгааныг тодорхойлж, шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:**Эхлэх хугацаа:** 2022 оны 3 дугаар сарын 10-ны өдөр**Дуусах хугацаа:** 2022 оны 6 дугаар сарын 01-ний өдөр**Байршил:** Улаанбаатар хот, Орхон, Говь-Алтай, Сүхбаатар, Төв, Баянхонгор аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан дуусаагүй орхигдсон зарим барилга, байгууламж**НЭГ. ҮНДЭСЛЭЛ**

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалд үндэслэн хийх “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын хүрээнд мэдлэг, ур чадвар бүхий этгээдийг шинжээчээр татан оролцуулна.

ХОЁР. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Шинжээч нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн дараах дуусаагүй орхигдсон барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөл, төсөв болон ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргах ажлыг хэрэгжүүлнэ. Үүнд:

Хүснэгт.1 Төсөл, арга хэмжээний жагсаалт

сая төгрөг

№	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсвийн тухай хуулиарх			
			Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
А			1	2	3	4
1	БШУЯ	Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/	2018	2020	2,500.0	600.0
2	БШУЯ	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 10 дугаар хороо/2	2019	2020	1,750.0	250.0
3	БШУЯ	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Говь-Алтай, Дэлгэр сум/	2019	2019	2,865.4	2,265.4

4	БШУЯ	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Говь-Алтай, Халиун сум/	2019	2019	1,166.3	666.3
5	БШУЯ	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 24 дүгээр хороо/	2019	2019	1,582.6	882.6
6	БШУЯ	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Эрдэнэцагаан сум/	2019	2019	2,160.0	1,910.0
7	БШУЯ	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 14 дүгээр хороо/	2018	2019	1,849.1	1,000.0
8	БШУЯ	Бага сургуулийн барилга /Төв, Бүрэн сум/	2019	2019	1,151.0	1,151.0
9	БШУЯ	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 1 дүгээр хороо, Богд-Ар хороолол/	2019	2019	2,000.0	2,000.0
10	БШУЯ	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо, 172 дугаар цэцэрлэг/	2019	2019	1,558.5	1,558.5
11	БШУЯ	Сургуулийн барилга, 960 суудал /Баянхонгор, Баянхонгор сум/	2012	2019	5,274.0	-
12	БШУЯ	Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/	2019	2021	5,166.1	500.0
13	ЭМЯ	Нийслэлийн ахмадын эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн 3 дугаар амбулаторийн өргөтгөл	2019	2020	8,600.0	5,600.0
Дүн					37,623.0	18,383.8

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Шинжээч нь төсөл, арга хэмжээ бүрээр дараах ажилбаруудыг гүйцэтгэж, аудитын талбарын болон тайлагналын үе шатанд аудитын багийг мэргэжил, арга зүйгээр хангана. Үүнд:

д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	Барилга, байгууламжийн зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангаж, төлөвлөлт, судалгаанд үндэслэсэн эсэхэд шинжээчийн дүгнэлт гаргах;	Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйл "Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх", 38 дугаар зүйл "Зураг төсөл зохиогчийн чиг үүрэг", 39 дүгээр зүйл. "Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эксперт, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Барилгын ажлын захиалагчийн дүрмийн 3 дугаар зүйл Захиалагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа,	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан зарим барилга, байгууламжийн зураг төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, ажлын гүйцэтгэл нь Монгол Улсын хууль тогтоомж, барилга, байгууламжийн норм, дүрэм, стандарт шаардлагад нийцэж, үр нөлөө бий болсон эсэхэд дүгнэлт гаргахад оршино.	<ul style="list-style-type: none"> - Хэрэгцээ шаардлагад үндэслэн төлөвлөсөн байх; - Хөрсний инженер геологийн дүгнэлт гаргуулсан эсэх; - Тооцоо судалгаанд үндэслэсэн байх - Холбогдох байгууллагуудаас техникийн нөхцөл, зөвшөөрлийг авсан байх; - Мэргэжлийн байгууллагаар холбогдох хууль журмын дагуу зураг төслийг хийлгэсэн эсэх; - Зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулсан байх; - Зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг иж бүрэн хангасан эсэх;

2	Барилга, байгууламжийн төсвийг баталсан зураг төслийн дагуу холбогдох хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиож, магадлалаар баталгаажуулсан эсэхэд дүгнэлт гаргах;	Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйл "Барилга байгууламжид тавих шаардлага", 24 дүгээр зүйл "Барилга байгууламжийн төсөв", 25 дугаар зүйл "Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх", 39 дүгээр зүйл "Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эксперт, Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм, Барилгын төсөв зохиох дүрэм"		Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байгууллага гүйцэтгэсэн; Холбогдох байгууллагаар хянаж баталсан зураг төслийн дагуу хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиож, магадлалаар баталгаажуулсан эсэх;
3	Барилга байгууламжийн суурь, бүтээц, угсралтын ажлыг зураг төсөл, техникийн шаардлагын дагуу хийсэн эсэхэд дүгнэлт гаргах;	Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйл "Барилга байгууламжид тавих шаардлага" 37 дугаар зүйл "Захиалагчийн чиг үүрэг" 38 дугаар зүйл "Зураг төсөл зохиогчийн чиг үүрэг", 40 дүгээр зүйл "Барилгын ажил гүйцэтгэгчийн чиг үүрэг", Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан Барилгын ажлын захиалагчийн дүрмийн 3 дугаар зүйл "Захиалагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа"		-Газар шороо болон суурийн ажил, -Цутгамал төмөр бетоны марк, арматурын анги, диаметр, -Хучилт, рамны ажил, -Хана, хамар ханын ажил, -Дээврийн ажил, -Хаалга, цонхны ажил, -Гадна дотор инженерийн шугам сүлжээний ажил, -Гадна тохижилт, заслын ажлын гүйцэтгэл тус бүрийг зураг төслийн дагуу болон барилгын норм дүрмийн дагуу хийж гүйцэтгэсэн эсэх;
4	Барилга, байгууламжийн гүйцэтгэлийн үе шатны ажлуудад хяналт тавьсан байдал, өгсөн зааварчилгаа, түүнийг хэрэгжүүлж ажилласан байдлыг нягтлан шалгаж, дүгнэлт гаргах;	Барилгын тухай хуулийн 42 дугаар зүйл "Зөвлөх үйлчилгээ", Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан Барилгын ажлын захиалагчийн дүрэм, БХБС-ын 2016 оны 178 дугаар тушаалаар баталсан Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм;		-Барилга угсралтын үе шатны ажил бүрд хяналт хэрэгжүүлсэн байх; -Хөрсний бодит байдал инженер геологийн дүгнэлттэй нийцсэн байх;
5	Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад орц, материалын тоо хэмжээ, нэр төрөл, чанар, агууламж зэргийг баталж, хянаж баталсан төсөв болон бодит гүйцэтгэл хооронд зөрүү илэрсэн тохиолдолд гүйцэтгэлийн өртөгт үзүүлэх нөлөөллийг тогтоож, төсөвт гарсан хэмнэлт, хэтрэлтийг тоо хэмжээ болон үнийн дүнгээр гаргах;	Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйл Барилга байгууламжийн төсөв, Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм, Барилгын төсөв зохиох дүрэм		Барилга, байгууламжийн хянаж, баталгаажуулсан зураг төсөлд заасан материалын орц, тоо хэмжээ, нэр төрөл, чанар, агууламжийг норм, стандарттай нийцэж буй эсэхийг хянах, давтан тооцоолол хийх; Хянаж баталсан ажлын тоо хэмжээ, төсвийг бодит гүйцэтгэлтэй харьцуулах, давтан тооцоолол хийх; Магадалшгүй ажлын зардал болон төсөл, арга хэмжээний зардлын хэтрэлт, хэмнэлтийг тооцох;

ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ХЭМЖЭЭ, ФОРМАТ

- Шинжээчийн үе шатны ажлын тайлангууд нь хавсралтууд орохгүйгээр 15-аас багагүй, 35-аас ихгүй хуудас /мөр хоорондын зай "single" үсгийн хэмжээ 12/ байх бөгөөд гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан, хавсралтуудтай байна.
- Шинжээчийн дүгнэлт гаргах үндэслэл болгосон холбогдох нотлох баримт, тайлангийн эх бичвэрийн файлыг хавсаргана.
- Үе шатны болон нэгдсэн тайлан боловсруулахад ашигласан хууль, стандарт, норм, дүрэм зэрэг шалгуур болгосон мэдээллийн эх үүсвэрийн жагсаалтыг хавсаргана.

ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Шинжээч нь ажлын даалгаварт заасан ажилбаруудыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, гэрээт ажлын хүрээнд хамрагдсан барилга, байгууламжийн зураг төсөл, төсөвт өртөг нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, норм, норматив, стандартаар тавигдах бусад шаардлагуудыг хангасан эсэх, барилга, байгууламжийг техникийн шаардлагын дагуу барьж эсэхийг хянан үзэж, дуусаагүй орхигдсон шалтгааныг тодорхойлон, нягтлан шалгаж, мэргэжлийн дүгнэлт гарган үр дүнг тусгасан шинжээчийн тайланг төсөл, арга хэмжээ бүрээр бэлтгэнэ.

Шинжээчийн тайланд дүгнэлт гаргах явцад илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн дүн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж, санал боловсруулж тусгана.

Шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

ТАВ. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шинжээч нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хүрээнд хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл, төсөв боловсруулах, магадлал хийх, дүгнэлт гаргах эрх бүхий, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, эдийн засгийн үр өгөөжийг тооцох, үнэлэх талаар мэргэшсэн, энэ чиглэлээр дүгнэлт гаргаж байсан, техникийн үйлчилгээ үзүүлж чадахуйц, тухайн салбарт ажиллаж байгаа болон ажлын дадлага, туршлагатай иргэн, хуулийн этгээд байна.

Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Шинжээчийн ажлын хүрээнд мэргэшсэн, тухайн салбарт ажиллаж ирсэн ажлын дадлага, туршлагатай, зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээд /түншлэлээр оролцох/-тэй хамтран ажиллах бөгөөд зөвлөх үйлчилгээг багаар үзүүлнэ. Гэрээт ажлыг гүйцэтгэх шинжээчийн багт дараах шаардлага тавигдана. Үүнд:

- Багийн ахлагч нь барилгын инженер, Монгол Улсын зөвлөх инженер, тэргүүлэх төсөвчин, магистр буюу түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 15 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай байх;
- Багийн гишүүд нь мэргэшсэн инженер, бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай байх;

- Судалгаа шинжилгээний болон шинжээчийн ажлын туршлагатай байх.

Шинжээч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

Ажлын даалгаврыг гүйцэтгэхээр шалгарсан хуулийн этгээд, шинжээчид нь ажил эхлэхийн өмнө аудитын багтай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх зэрэг нэмэлт тодруулга авч ажиллаж болно.

Үе шатны ажлын явцад илэрсэн, хэрэгжүүлэх явцад үүссэн, шийдвэрлэх боломжгүй асуудал бий болсон тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

Бүрдүүлэх материал:

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, боловсролын зэргийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бусад үнэмлэх сертификатын хуулбар, аж ахуйн нэгжийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, албан бичиг;
- Ажлын туршлага тодорхойлсон дэлгэрэнгүй намтар /багийн гишүүн тус бүрээр/;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх);

Дээрх шаардлагыг хангасан тухай нотлох баримтын баталгаажсан хуулбар ирүүлж, цуглуулсан бүх баримт, мэдээлэл, зөвлөмжийг хавсаргана.

ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.

ОРОЛЦОХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн шинжээч сонгон шалгаруулах зар/урилга болон өөрсдийн оролцох хүсэлтийн дагуу бид [Шинжээчийн үйлчилгээний нэр]-г _____ төгрөгөөр гүйцэтгэх саналыг үүгээр хүргүүлж байна.

Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг: _____

Холбоо барих утас: _____

ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

3.1. Ерөнхий танилцуулга

.....

(Оролцогч хуулийн этгээд болон хувь хүн /баг/ нь ерөнхий танилцуулгад холбогдох үйл ажиллагаа явуулах бүртгэлийн болон эрхийн гэрчилгээг хавсаргаж ирүүлнэ)

3.2. Хуулийн этгээд/баг/хувь хүний чадварыг харуулж чадах сүүлийн 3 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл

Доорх хүснэгтийн дагуу хуулийн этгээд/баг/хувь хүн дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү.

Гүйцэтгэсэн ажлын нэр:		Улсын нэр:
Байршил:		Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):
Захиалагчийн нэр:		Ажилтны тоо:
Хаяг:		Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүн-сарын тоо:
Эхэлсэн он сар өдөр:	Дууссан он сар өдөр:	Ажлын өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:
Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн нэр (хэрэв байвал):		Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн ажилтнуудын ажилласан сарын тоо:
Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд:		
Төслийн талаарх товч танилцуулга:		
Төслийн хүрээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:		

Хуулийн этгээд/баг/хувь хүний нэр: _____

САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: _____

Байгууллагын нэр: _____

Мэргэжилтний нэр: _____

Мэргэжил: _____

Төрсөн он, сар, өдөр: _____

Тухайн байгууллагад ажилласан жил: _____ Иргэншил: _____

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: _____

Хариуцах ажил: _____

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшнийг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ¹**

№	Нэр	Хаяг, байршил	Хүчин чадал
1	Ажлын байр		
2	Тоног төхөөрөмж		

БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Нэр	Албан тушаал	Хариуцах ажил

АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

- Ажлын хөтөлбөрийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр гаргаж ирүүлнэ.
- Ажил гүйцэтгэх аргачлалыг дэлгэрэнгүй гаргаж ирүүлнэ.

¹ Ажлын байр, тоног төхөөрөмжийн зургийг хавсаргаж ирүүлнэ.